



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 01

Сүхбаатар

“Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, сахилга,
хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлах тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4.3, 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх замаар төр төсвийн байгууллагын үйл ажиллагааны чадавхи, үр нөлөө, төрөөс иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оныг “Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласугай.

2.Зарласан жилийн төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Зарласан жилийн хүрээнд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлж, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага, ажил албаныхаа онцлогт тулгуурлан бодлого зорилт дэвшүүлсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг төр, төсвийн нийт байгууллагын төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

4.Зарласан жилийн ажлын биелэлтийг хянах, удирдлага зохицуулалтаар хангаж, үр дүнг тооцож ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА